

**“Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг
хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн Дэд төсөл 2**

**Монгол Улсын Хот
байгуулалтын салбарын
чадавхийг бэхжүүлэх төслийн 2
дугаар үе шат (MUGCUP2)**

**ТӨСЛИЙН ТӨГСГӨЛИЙН ТАЙЛАН
(Хоёр дахь жил)**

2019 оны 1 дүгээр сар

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

**АЛМЕК корпораци
ТАМАНО Консалтантс ХХК
Ориентал Консалтантс Глобал ХХК**

EI
JR
19-008

**“Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг
хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн Дэд төсөл 2**

**Монгол Улсын Хот
байгуулалтын салбарын
чадавхийг бэхжүүлэх төслийн 2
дугаар үе шат (MUGCUP2)**

**ТӨСЛИЙН ТӨГСГӨЛИЙН ТАЙЛАН
(Хоёр дахь жил)**

2019 оны 1 дүгээр сар

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

**АЛМЕК корпораци
ТАМАНО Консалтантс ХХК
Ориентал Консалтантс Глобал ХХК**

Валютын ханш

Мөнгөн тэмдэгт	Ханш
Америк доллар (USD1 = ₮)	113.385
Монгол төгрөг (MNT1 = ₮)	0.04377

(2018 оны 12 дугаар сарын ЖАЙКА-гийн ханш)

Гарчиг

I. Төслийн тухай ерөнхий мэдээлэл	1
1. Улс	1
2. Төслийн нэр	1
3. Төсөл хэрэгжих хугацаа (Төлөвлөсөн ба бодит).....	1
4. Үндэслэл (Хэлэлцүүлгийн тэмдэглэлээс).....	1
5. Ерөнхий зорилго ба төслийн зорилт (Хэлэлцүүлгийн тэмдэглэлээс) .	2
6. Хэрэгжүүлэгч байгууллагууд	2
II. Төслийн үр дүн	3
1. Төслийн үр дүн	3
2. Төслийн гүйцэтгэл	9
3. Төслийн загварын матрицад (ТЗМ) өөрчлөлт оруулсан байдал	15
4. Бусад	17
III. Хамтарсан үнэлгээний үр дүн	17
1. ДАС үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн үнэлгээний үр дүн	17
2. Хэрэгжилтэнд нөлөөлж буй гол хүчин зүйлс ба үр дүн	23
3. Төслийн эрсдэлийн менежментийн үр дүнгийн үнэлгээ	26
4. Авсан сургамж.....	29
IV. ЖАЙКА-гийн төсөл хэрэгжиж дууссаны дараа ерөнхий зорилгод хүрэх	31
1. Ерөнхий зорилгыг биелүүлэх хэтийн төлөв	31
2. Ерөнхий зорилгод хүрэх Монголын талын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжүүлэх бүтэц.....	32
3. Монголын талд өгөх зөвлөмж	34
4. Төслийн хяналт, шинжилгээний ex-post үнэлгээ.....	35
ХАВСРАЛТ 1: Төслийн үр дүн.....	37
ХАВСРАЛТ 2: ЖАЙКА-гийн төслийн хүрээнд боловсруулсан тайлан, гарын авлага, судалгаа, сургалт, сурталчилгааны материалууд	72
ХАВСРАЛТ 3: ТТМ (бүх хувилбар).....	74

Төслийн төгсгөлийн тайлан

I. Төслийн тухай ерөнхий мэдээлэл

1. Улс

Монгол Улс

2. Төслийн нэр

Төслийн нэр	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлт болон хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх төсөл
Дэд төсөл 2-ын нэр	Монгол Улсын Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шат (MUGCUP2)

3. Төсөл хэрэгжих хугацаа (Төлөвлөсөн ба бодит)

Хугацаа	2015 оны 2-р сараас – 2018 оны 12-р сар
---------	---

4. Үндэслэл (Хэлэлцүүлгийн тэмдэглэлээс)

Улаанбаатар хотын хүн ам тасралтгүй өсөж байна. 1998 онд хотын хүн ам 650,000 байсан бол 2012 оны байдлаар 1,320,000 орчим болж өссөн бөгөөд жилийн дундаж өсөлт 5.2 хувьтай байна.

Хүн амын огцом өсөлт хотод хүндрэл бэрхшээл учруулдаг бөгөөд Улаанбаатар хотын хувьд ч орон сууцны ханган нийлүүлэлт эрэлт хэрэгцээнээс хоцорч байгаа юм. Хотын 183 мянган өрх буюу 930 мянган хүн цахилгаан хангамжийг эс тооцвол үндсэн дэд бүтэц болон үйлчилгээгүй гэр хороололд оршин сууж байна. Гэр хороолол нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсдээр тасралтгүй тэлж, Улаанбаатар хотын хотжилтын санаа зовоосон асуудлын нэг болоод байгаа билээ. Гэр хорооллын халаалтанд нүүрс хэрэглэж байгаа нь ус, хөрс, агаарын хяналтгүй бохирдлыг үүсгэж, нөхцөл байдлыг улам доройтуулж байна. Ариун цэврийн байгууламж нь цэвэрлэх байгууламжгүй байгаа нь байдлыг хүндрүүлж буй бас нэг асуудал юм.

Улаанбаатар хот хэдийгээр 1954 оноос хойш нийт 6 удаа тухайн үеийн нийгэм, эдийн засгийн бодит нөхцөл байдалд тохируулан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж ирсэн боловч сүүлийн 20 жилд нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлүүдээс шалтгаалан ерөнхий төлөвлөгөөг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж чадахгүй явж ирсэн байна. Гэвч УИХ-ын 2013 оны тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг батлагдсанаас хойш

Улаанбаатар хот уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр ажиллаж ирсэн боловч, хараахан боловсруулж дуусаагүй байна.

Түүнчлэн хотын удирдлага хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, хотын төвийн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцуудыг буулган, шинээр барих замаар гэр хорооллыг сайжруулах чиглэлээр ихээхэн хүчин чармайлт тавин ажиллаж байна. Хотын удирдлага гэр хорооллыг дахин төлөвлөж, хөгжлүүлэх 21 төслийг сонгосноос 18 төслийг нь хувийн хэвшлийнхэн нийслэлийн холбогдох байгууллагын хяналтын дор хэрэгжүүлж эхлээд байгаа болно. Мөн гэр хорооллын оршин суугчдын амьдрах орчныг сайжруулахын тулд оршин суугчдын эрэлт хэрэгцээний суурь судалгаа хийсний үндсэн дээр гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах бэлтгэлийг хангаж байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн дүрэм журам, зохицуулалтуудыг боловсруулан, батлуулж байна.

Түүнчлэн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байгаа болно. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр эдгээр арга хэмжээг авч ирсэн хэдий ч амжилттай хэрэгжсэн хот байгуулалтын төсөл байхгүй, хотыг хөгжүүлэх төслийн бат бэх тогтолцоо, механизм байхгүй байна.

5. Ерөнхий зорилго ба төслийн зорилт (Хэлэлцүүлгийн тэмдэглэлээс)

	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн анхны хувилбар	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн шинэчилсэн хувилбар (2016 оны 10-р сарын 7-ны хурлын протокол)
Ерөнхий зорилго	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн нийслэл хотын оршин суух нөхцөл, хотоос иргэдэд үзүүлэх үйлчилгээг хот байгуулалтын төлөвлөлтөөр дамжуулан сайжруулах	УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт үндэслэн нийслэл хотын оршин суух нөхцөл, хотоос иргэдэд үзүүлэх үйлчилгээг хот байгуулалтын төлөвлөлтөөр дамжуулан сайжруулах
Төслийн зорилт	Хот төлөвлөлт, хот байгуулалтын төсөл хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлснээр иргэдийн амьдрах орчныг сайжруулахад оруулах хувь нэмэр дээшилсэн байх	

6. Хэрэгжүүлэгч байгууллагууд

Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) (БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газар; Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар; Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газар; Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газар), Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар (одоогийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар); Төрийн Орон сууцны корпораци

(ТОСК)

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс; (хуучин нэрээр Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс); Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар (хуучин нэрээр Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар); Гэр хорооллын дэд бүтцийн газар (хуучин нэрээр Гэр хорооллын хөгжлийн газар болон Гэр хорооллыг орон сууцжуулах төслийг нэгтгэсэн); Өмчийн харилцааны газар (Газрын албаны зарим бүтцийг салгасан); Авто замын хөгжлийн газар; Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн НӨҮГ (хуучин нэрээр Нийслэлийн Хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн); Нийслэлийн Орон сууцны корпораци (НОСК)).

II. Төслийн үр дүн

1. Төслийн үр дүн

(1) 1-1 Японы талын оролцоо (Төлөвлөсөн ба бодит)

Оролцоо	439.73 сая Японы иен*
Мэргэжилтнүүдийн томилгоо	<p>1 мэргэжилтэн (урт хугацааны 7 хүн/сар): Ахлах зөвлөх (2015 оны 9-р сарын 15-ыг хүртэл)</p> <p>12 мэргэжилтэн (богино хугацааны, нийт 73.12 хүн сар) (Хавсралт 1 (1)-ийг үзнэ үү)</p> <ul style="list-style-type: none">- Төслийн багийн ахлагч / Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл / Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой хууль, эрх зүйн тогтолцоо- Дэд ахлагч / Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх_төсөл / Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой хууль, эрх зүйн тогтолцоо- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл / Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журам- Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл- Дэд бүтцийн төлөвлөлт / Архитектор- Дэд бүтцийн төлөвлөлт (3 мэргэжилтэн)- Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний аргачлал / Нөхөх олговрын тогтолцоо- Төслийн санхүүжилт / Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо- Сургалтын төлөвлөлт / Мэдээлэл, сурталчилгааны

	төлөвлөлт (2 мэргэжилтэн) - Сургалтын төлөвлөлт / Мэдээлэл, сурталчилгааны төлөвлөлт / Институцийн хөгжил
Сургалтанд хамруулах	16 мэргэжилтэн (Япон улсад богино хугацааны сургалтанд хамрагдах)
Тоног төхөөрөмж нийлүүлэх	Олон үйлдэлтэй фото-хувилах машин худалдан авсан зардал - 359,599 Японы иен
Тухайн улс орон дахь үйл ажиллагааны зардал	Сургалт, семинар болон хурал зохион байгуулах зардал, дотоодын ажилтнуудын цалин, орчуулгын зардал болон бусад - 15.943 сая Японы иен*

Тайлбар: “ * ” тэмдэглэгээтэй дүнд Дэд төсөл 1 болон 2-ын зардал багтсан.

(2) 1-2 Монголын талын оролцоо (Төлөвлөсөн ба бодит)

- (a) Төслийн Удирдах хороо болон Ажлын хэсгийн гишүүд, БХБЯ болон НЗДТГ-ын хамтран ажиллагч байгууллагуудын мэргэжилтнүүдийн оролцоо (дэлгэрэнгүйг Хавсралт 1 (2)-оос үзнэ үү).
- Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)
 - Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
 - Бодлого, төлөвлөлтийн газар;
 - хуучин нэрээр Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газар;
 - хуучин нэрээр Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газар;
 - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар;
 - Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар;
 - НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс (хуучин нэрээр Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс);
 - Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар (хуучин нэрээр Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар);
 - Гэр хорооллын дэд бүтцийн газар (хуучин нэрээр Гэр хорооллын хөгжлийн газар болон Гэр хорооллыг орон сууцжуулах төслийг нэгтгэсэн);
 - Өмчийн харилцааны газар (Газрын албаны зарим бүтцийг салгасан);
 - Авто замын хөгжлийн газар;
 - Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн НӨҮГ (хуучин нэрээр Нийслэлийн Хот байгуулалт, зураг төслийн хүрээлэн);
 - Нийслэлийн Орон сууцны корпораци (НОСК)
- (b) Офисын тохиромжтой талбай, шаардлагатай тоног төхөөрөмж буюу бичгийн

ширээ

(с) Уулзалтын өрөө

(g) Төсөлтэй холбоотой зөв мэдээлэл, тоо баримтаар (газрын зураг ба фото зураг)

(h) Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай урсгал зардал мөн аймаг, орон нутагт ажиллах хамтран ажиллагч байгууллагуудын мэргэжилтнүүдийн томилолтын зардал

(3) 1-3 Үйл ажиллагаа (Төлөвлөсөн ба бодит)

Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн анхны үйл ажиллагаа	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн шинэчилсэн үйл ажиллагаа (2018 оны 5-р сарын 25-ны хурлын протокол)	Нөхцөл байдал
5-1: Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагаанд харьцуулсан судалгаа хийх, тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийх	5-1: Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагаанд харьцуулсан судалгаа хийх, тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийх	5-1: Төслийн талбайг тодорхойлсон.
5-2: Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслүүдийн нөхцөл байдал, ололт, амжилтыг судлах, тулгарч буй асуудлуудад нь дүн шинжилгээ хийх	5-2: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх бусад төслүүдийн нөхцөл байдал, ололт, амжилтыг судлах, тулгарч буй асуудлуудад нь дүн шинжилгээ хийх (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслүүд)	5-2: Төслийн талбайг тодорхойлсон.
	5-3: Орон нутагт хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл байдал, тулгарч болох асуудлуудыг судлах (төслийн 3 төрлөөр)	5-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай тул БХБЯ-ны хүсэлтээр шинээр нэмж оруулсан.
	6-1: Орон сууцны зах зээлийн одоогийн нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийх	6-1: Нэгэнт оруулсан үр дүнг тодруулахын тулд шинээр нэмсэн.
	6-2: Орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн дунд хугацааны дүн шинжилгээ хийх	6-2: Улаанбаатар хотын орон сууцны нийлүүлэлтийн илүүдэлтэй байдлыг харгалзан үзэж, нэмсэн.

Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн анхны үйл ажиллагаа	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн шинэчилсэн үйл ажиллагаа (2018 оны 5-р сарын 25-ны хурлын протокол)	Нөхцөл байдал
	6-3: Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг боловсруулах	6-3: Улаанбаатар хотын орон сууцны нийлүүлэлтийн илүүдэлтэй байдлыг харгалзан үзэж, нэмсэн.
<p>6-1: Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үүднээс хотыг дахин хөгжүүлэх бодлогыг нягтлан үзэх ба шаардлагатай бол бодлогыг боловсронгуй болгох (төслийн 3 төрлөөр)</p> <p>6-2: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх 5 жилийн зардлын тооцоог дэд бүтцийн зардлын хамт тодруулах (төслийн 3 төрлөөр)</p>	<p>7-1: Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үүднээс хотыг дахин хөгжүүлэх бодлогыг нягтлан үзэх ба шаардлагатай бол бодлогыг боловсронгуй болгох (төслийн 3 төрлөөр)</p> <p>7-2: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг 2020 он хүртэл хэрэгжүүлэх зардлын тооцоог дэд бүтцийн зардлын хамт тодруулах (төслийн 3 төрлөөр)</p>	7-2: Хугацааг тодруулсан.
<p>7-1: Загвар төслийг сонгох (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p> <p>7-2: Бие даасан инженерийн дэд бүтцийн төлөвлөлт боловсруулах (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p> <p>7-3: Загвар төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p> <p>7-4: Загвар төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p>	<p>8-1: Загвар төслийг сонгох (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p> <p>8-2: Бие даасан инженерийн дэд бүтцийн төлөвлөлт боловсруулах (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p> <p>8-3: Загвар төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)</p> <p>Хасагдсан</p>	Загвар төслийн байршлыг ТУХ-ны 2017 оны 6-р сарын 8-ны хурлаар сонгосон бөгөөд ЖАЙКА-гийн төслийн хэрэгжилтийн хугацаанд загвар төслийг хэрэгжүүлэх цаг хугацаа байхгүй тул хасагдсан.
8-1: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулах	9-1: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах норм, дүрэм, журам, стандартын төслийг боловсруулах	9-1: Нэр томъёог өөрчилсөн.

Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн анхны үйл ажиллагаа	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн шинэчилсэн үйл ажиллагаа (2018 оны 5-р сарын 25-ны хурлын протокол)	Нөхцөл байдал
<p>8-2: НИТХ-аар батлагдсан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>8-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагыг боловсруулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>8-4: Төсөл төлөвлөх болон хэрэгжүүлэх үйл явцыг стандартчилах (төслийн 3 төрлөөр)</p> <p>8-5: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг санал болгох (төслийн 3 төрлөөр)</p>	<p>9-2: Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад санал, зөвлөмж өгөх</p> <p>9-3: УИХ-аар батлагдах Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөлд санал, зөвлөмж өгөх</p> <p>Хасагдсан</p> <p>9-4: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд санал, зөвлөмж өгөх (төслийн 3 төрлөөр)</p> <p>9-5: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагыг боловсруулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>Хасагдсан</p> <p>Хасагдсан</p>	<p>9-2: БХБЯ-ны хүсэлтээр шинээр нэмсэн.</p> <p>9-3: БХБЯ-ны хүсэлтээр шинээр нэмсэн.</p> <p>Нөхцөл байдалд үл нийцсэн тул хасагдсан.</p> <p>9-4: Нэгэнт оруулсан үр дүнг тодруулахын тулд шинээр нэмсэн.</p> <p>Нөхцөл байдалд үл нийцсэн тул хасагдсан.</p> <p>Нөхцөл байдалд үл нийцсэн тул хасагдсан.</p>
<p>9-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах аргачлалыг тодорхойлох (төслийн 3 төрлөөр)</p> <p>9-4: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн талаарх олон нийтийн</p>	<p>10-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах аргачлалыг тодорхойлох (төслийн 3 төрлөөр)</p> <p>10-4: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн талаарх олон нийтийн</p>	

Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн анхны үйл ажиллагаа	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн шинэчилсэн үйл ажиллагаа (2018 оны 5-р сарын 25-ны хурлын протокол)	Нөхцөл байдал
<p>ойлголтыг сайжруулахын тулд сурталчлан таниулах материал боловсруулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>9-5: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаар баримтлах бодлогын тухай иргэдэд мэдээлэл өгөх (төслийн 3 төрлөөр)</p>	<p>ойлголтыг сайжруулахын тулд сурталчлан таниулах материал боловсруулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>10-5: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаар баримтлах бодлогын тухай иргэдэд мэдээлэл өгөх (төслийн 3 төрлөөр)</p>	
<p>10-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх чадавхийн одоогийн байдал болон тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийх (төслийн 3 төрлөөр)</p> <p>10-4: Нийслэлээс үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх</p> <p>10-5: НЗДТГ болон холбогдох байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулах (хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг оролцуулан)</p> <p>10-7: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>10-8: Япон Улсад хотыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулах (нэг удаа)</p>	<p>11-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх чадавхийн одоогийн байдал болон тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийх (төслийн 3 төрлөөр)</p> <p>11-4: Нийслэлээс үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх</p> <p>11-5: НЗДТГ болон холбогдох байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулах (хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг оролцуулан)</p> <p>11-7: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах (төслийн 3 төрлөөр)</p> <p>11-8: Япон Улсад хотыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулах (нэг удаа)</p> <p>11-9: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургалт, семинарын агуулгыг боловсруулах</p>	<p>11-9: Загвар төслийг хэрэгжүүлэх үүднээс хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг чадавхижуулах хэрэгцээ шаардлагад тулгуурлан шинээр нэмсэн болно.</p>

Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн анхны үйл ажиллагаа	Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн шинэчилсэн үйл ажиллагаа (2018 оны 5-р сарын 25-ны хурлын протокол)	Нөхцөл байдал
	11-10: Сургагч багшид зориулсан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургалтыг зохион байгуулах	11-10:Загвар төслийг хэрэгжүүлэх үүднээс хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг чадавхижуулах хэрэгцээ шаардлагад тулгуурлан шинээр нэмсэн болно.

Тайлбар: 1. Дээрхээс бусад Үйл ажиллагаа нь Дэд төсөл 1-ийн үйл ажиллагаанд хамаарна.

2. Төслийн 3 төрөл: а. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, б. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл, в. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төсөл.

2. Төслийн гүйцэтгэл

(1) 2-1 Үр дүн ба шалгуур үзүүлэлтүүд

Үр дүн	Бодит шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
5: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн одоогийн байдал, тулгамдсан асуудлуудыг тодруулсан. (төслийн 3 төрлөөр)	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн одоогийн байдал, тулгамдсан асуудлууд	<p>Ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>5-1: Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагааны талаар Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газар (хуучин нэрээр) ба Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй ярилцлага хийх замаар болон төсөл хэрэгжүүлж буй газрын оршин суугчдын сэтгэл ханамжийн судалгаа хийж, газар дээр нь очиж танилцан тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийсэн.</p> <p>5-2: Төслийн хэрэгжилтийг үнэлж, Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газар (хуучин нэрээр) болон Ерөнхий төлөвлөгөөний газраас (хуучин нэрээр) хэрэгжүүлж буй гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслүүдэд тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийн, газар дээр нь очиж танилцсан.</p> <p>5.3: Говь-Сүмбэр аймгийн төв Чойр, Дархан-Уул аймгийн төв Дархан болон Орхон аймгийн төв Эрдэнэт хотуудад хамтран ажиллагч байгууллагуудын мэргэжилтнүүдийн хамтаар ажиллаж, аймгийн холбогдох мэргэжилтнүүд болон Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй ярилцлага хийх замаар хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн (төслийн 3 төрлөөр) хэрэгжилтийн одоогийн байдлыг үнэлж дүгнэн, тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, газар дээр нь очиж</p>

Үр дүн	Бодит шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
		танилцсан.
6: Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг боловсруулсан. (Дэд төсөл 2)	Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг боловсруулсан.	Ажлыг гүйцэтгэсэн. 6-1: Орон сууцны зах зээлийн одоогийн байдлыг судлан, эх сурвалжийн тойм болон үл хөдлөх хөрөнгийн компаниудтай ярилцлага хийх замаар тулгарч буй асуудалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд Улаанбаатар хотын орон сууцны зах зээлийн судалгаа хийсэн. 6-2: Улаанбаатар хотын орон сууцны зах зээлийн судалгааны хүрээнд орон сууцны эрэлт, нийлүүлэлтэд дүн шинжилгээ хийсэн. 6-3: Нийслэлийн Орон сууцны корпорацитай (НОСК) хамтран Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг (БОО) орон сууцаар хангах бодлогыг боловсруулсан. Энэхүү бодлого нь 2018 оны 2-р сарын 27-нд НИТХ-аар батлагдсан.
7: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар баримтлах бодлого ба түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг тодруулсан. (Дэд төсөл 2)	Улаанбаатар хотын хотыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар баримтлах бодлого ба түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулсан.	Ажлыг гүйцэтгэсэн. 7-1: Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тусгасан хотыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар баримтлах бодлогын талаар нягтлан үзэж, Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газартай хэлэлцсэн. 7-2: НОСК-тай хамтран боловсруулсан Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогын хүрээнд Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар болон Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар нь хотыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх 5 жилийн зардлын тооцоог хийсэн.
8: Загвар төслийг хэрэгжүүлэх замаар гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг дэмжсэн. (Дэд төсөл 2)	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийн төлөвлөгөөг боловсруулсан.	Үйл ажиллагаа 8-3: Загвар төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил зогссоноос үүдэн ажлын биелэлт дутуу байна. Харамсалтай нь үр дүнд хүрэх боломж бага байна. 8-1: ТУХ-ны 2017 оны 6-р сарын хуралдаанаар загвар төслийг хэрэгжүүлэх байршлыг Чингэлтэй дүүргийн 7-р хороо болон Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт сонгосон. 8-2: Нийслэлээс Дэд бүтцийн төвийг санал болгон, барьж байгуулж байгаа тул Гэр хорооллын дэд бүтцийн газраар удирдуулан Чингэлтэй дүүргийн 7-р хороо болон Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт бие даасан инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийг боловсруулсан. 8-3: MUGCUP2 Төслийн баг төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл болон нэгж

Үр дүн	Бодит шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
		<p>талбаруудыг өөрчлөн зохион байгуулах төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Гэвч үйл ажиллагаа зогссон. Учир нь Нийслэлийн зүгээс Чингэлтэй дүүргийн 7-р хороо болон Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт загвар төсөл хэрэгжүүлэх талаар НИТХ-д санал оруулан, батлуулахаар өргөн барихгүй байгаа ба загвар төсөл хэрэгжүүлэх газрын оршин суугчдад гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн талаар тайлбарлан таниулахгүй байна.</p> <p>Үүнээс гадна MUGCUP2 Төслийн баг гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг боловсруулсан. БХБЯ тус бодлогыг хэрэгжүүлэх талаар судалж эхлээд байна.</p>
<p>9. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлсон.</p>	<p>(1) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах долоон дүрэм, журмыг боловсруулан, батлуулсан.</p> <p>(2) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагыг боловсруулсан.</p>	<p>Ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах зургаан дүрэм, журмыг боловсруулан, батлуулсан ба “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”-ын төслийг батлуулаагүй байна. Мөн мэргэжилтнүүдэд зориулсан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагыг эцэслэн боловсруулахаар ажиллаж байна. Тиймээс энэ Үйл ажиллагааг бүрэн биелүүлэх боломж өндөр байна.</p> <p>Төсөл дуусахтай зэрэгцүүлээд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагыг боловсруулж дуусгана. Мөн “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”-ын төслийг удахгүй эцэслэн боловсруулж, БХБ-ын Сайдын тушаалаар батлуулахаар төлөвлөж байна.</p> <p>9-1: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах долоон дүрэм, журмаас зургаа нь батлагдан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:</p> <p>1) Төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам (БХБ-ын Сайдын 2016 оны 5-р сарын 11-ний өдрийн 84 дүгээр тушаалаар баталсан);</p> <p>2) Төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар (БХБ-ын Сайдын 2016 оны 7-р сарын 5-ны өдрийн 125 дугаар тушаалаар баталсан);</p> <p>3) Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн</p>

Үр дүн	Бодит шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
		<p>барилгажуулах үйл ажиллагааны журам (БХБ-ын Сайдын 2016 оны 7-р сарын 30-ны өдрийн 126 дугаар тушаалаар баталсан);</p> <p>4) Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам (БХБ-ын Сайдын 2016 оны 7-р сарын 5-ны өдрийн тушаалаар баталсан);</p> <p>5) Нөхөх олговор олгох журам (Засгийн газрын 2018 оны 7-р сарын 9-ний өдрийн 222 дугаар тогтоолоор баталсан);</p> <p>6) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам (Засгийн газрын хурлаар батлагдсан ч, албажаагүй байна.)</p> <p>“Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”-ын төслийг эхний байдлаар боловсруулсан.</p> <p>9-2: БХБЯ-ны Ажлын хэсэг Хот байгуулалтын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд MUGCUP2 Төслийн баг санал зөвлөмж өгч ажилласан. Гэвч цаашид хэлэлцүүлэг хийгээгүй байна.</p> <p>9-3: MUGCUP2 Төслийн баг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг боловсруулах явцад санал зөвлөмж өгч ажилласан ба энэхүү хууль нь 2016 оны 6-р сарын 26-ны өдөр УИХ-аар батлагдсан.</p> <p>9-4: БХБЯ болон НЗДТГ-ын хамтран ажиллагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэн хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам болон Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын төсөл боловсруулахад санал зөвлөмж өгч ажилласан.</p> <p>9-5: Ажлын хэсгийн гишүүдийг сургалтанд хамруулан мэргэжилтнүүдэд зориулсан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагыг хамтран боловсруулсан.</p>
<p>10. Иргэдийн оролцоо болон олон нийтэд мэдээлэл өгөх үйл ажиллагааг дэмжсэн.</p>	<p>(1) Хот байгуулалтын төслийн үйл ажиллагаанд сурталчилгааны хэрэгслийг ашиглах боломж</p> <p>(2) Сурталчилгааны хэрэгслийг ашигласан байдал</p>	<p>Ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>10-3: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх гарын авлагад иргэдийн оролцооны аргачлалын талаар оруулсан. Гэвч энэхүү аргачлалыг загвар төслийн хэрэгжилтэд туршаагүй тул 3-р үзүүлэлтийг хэрэглэх боломжгүй байсан.</p> <p>10-4: Видео кино, товхимол зэрэг</p>

Үр дүн	Бодит шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
	(3) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөлд хамрагдах зорилтот өрхүүдийн төслийн талаарх ойлголтын түвшин	<p>сурталчилгааны дөрвөн хэрэгслийг дор дурдсан үйл ажиллагаанд зориулан бэлдсэн: 1) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн танилцуулга; 2) Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих; 3) Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл; 4) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл. Эдгээр видео кино, товхимлыг олон нийтэд зориулан НЗДТГ, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар болон Гэр хорооллын дэд бүтцийн газрын вэб сайтад байршуулсан болно. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн нийт 900 орчим танилцуулга товхимлыг сургалтаар дамжуулж хамтран ажиллагч байгууллагуудын болон орон нутгийн мэргэжилтнүүдэд, иргэдэд тараасан. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих үйл ажиллагааны видео танилцуулгыг НХТЕТГ-ын вэб сайтад байршуулж, 250 товхимлыг иргэдэд тараасан. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах болон гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслүүдийн танилцуулга видео болон товхимлыг шинээр боловсруулж дуусаад байна.</p> <p>10-5: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар баримтлах бодлогыг НЗДТГ-ын вэб сайтад байршуулсан.</p>
11: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлсэн.	<p>(1) Өөрийн үнэлгээнд тулгуурлан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах</p> <p>(2) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх сургалтын агуулга боловсруулах</p> <p>(3) Сургалтанд хамрагдагсадын тоо</p>	<p>Ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>11-3: Хамтран ажиллагч байгууллагуудаас хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн хэрэгжилтийн одоогийн байдлын талаар мэдээлэл цуглуулж, тус төслүүдийг хэрэгжүүлэх чадавхийн талаар дүн шинжилгээ хийсэн.</p> <p>11-4: Газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагааны талаар төслийн талбай дахь оршин суугчдын сэтгэл ханамжийн судалгаа хийсэн.</p> <p>11-5: Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах болон гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлэгч Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулсан.</p> <p>11-7: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа ялангуяа гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл</p>

Үр дүн	Бодит шалгуур үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
		<p>хэрэгжүүлэх талаарх сургалтыг Улаанбаатар хотод нийт 5 удаа зохион байгуулсан. Тус сургалтанд амжилттай хамрагдсан аймаг, нийслэлийн нийт 304 мэргэжилтэнд сертификат гардуулсан. Түүнээс гадна Гэр хорооллын дэд бүтцийн газар болон Гэр хорооллыг орон сууцжуулах төслийн мэргэжилтнүүдэд ажлын байран дахь сургалтын хүрээнд Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төсөл хэрэгжүүлэх талаар нийт 12 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Гэвч УИХ-ын 2016 оны сонгуулийн дараа сургалтанд хамрагдсан байсан Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл болон Гэр хорооллын дэд бүтцийн газрын мэргэжилтнүүдийг ажлаас нь чөлөөлж, халаа сэлгээ хийсэн.</p> <p>11-8: 2017 оны 2-р сард Япон улсад сургалт зохион байгуулсан бөгөөд БХБЯ, ГЗБГЗЗГ, НЗДТГ болон НЗТХ-ийн нийт 16 мэргэжилтэн, албан хаагчид тус сургалтанд хамрагдсан болно. Сургалтын дараах санал асуулгын үр дүн зэрэг байсан ба оролцогчид Япон улсын хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүд болон бага орлоготой өрхүүдийн орон сууцны бодлогын талаар ойлголттой болсноо онцолсон.</p> <p>11-9: МАЭ-ээс зохион байгуулдаг зөвлөх, мэргэшсэн архитекторын зэрэг горилох, сунгах сургалтын хөтөлбөрийн агуулгын тодорхой хэсгийг боловсруулсан.</p> <p>1-10: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургагч багш нарыг мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага болон танилцуулга материалыг боловсруулж, тэдэнд зориулсан дадлага сургалтуудыг зохион байгуулж бэлтгэсэн. Сургалтад амжилттай хамрагдсан 17 мэргэжилтэнд сертификат гардуулсан.</p>

Тайлбар: Дээрхээс бусад Үр дүн нь Дэд төсөл 1-ийн үр дүнгүүдэд хамаарна.

(2) 2-2 Төслийн зорилт ба шалгуур үзүүлэлтүүд

Төслийн загварын матрицын шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэн “Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлснээр иргэдийн амьдрах орчныг сайжруулахад оруулах хувь нэмэр оруулах” гэсэн Төслийн зорилгод хүрсэн гэж үзсэн. Дараах хүснэгтэд төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийх үеийн төслийн зорилгын биелэлтийг харуулав.

Төслийн зорилт	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлсэнээр иргэдийн амьдрах орчныг сайжруулахад оруулах хувь нэмэр дээшилсэн байх	<p>(1) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдлэг, чадварыг сайжруулах</p> <p>(3) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхтэй холбогдолтой сургалтанд гарын авлагыг ашиглах</p> <p>(5) Хотыг дахин хөгжүүлэх төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс НЗДТГ-ын холбогдох байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах</p>	<p>Шалгуур үзүүлэлт 1: Биелсэн.</p> <p>Монгол болон Япон улсад зохион байгуулсан сургалт, загвар төслийн төлөвлөгөө боловсруулах ажлын байран дахь сургалт, Ажлын хэсэг болон дэд Ажлын хэсгийн хурлууд, дүрэм журам боловсруулах Ажлын хэсгийн хурлууд ба сургагч багшид зориулсан сургалтуудаар дамжуулан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл боловсруулах мэргэжилтэн, албан тушаалтнуудын мэдлэг, чадвар сайжирсан.</p> <p>Шалгуур үзүүлэлт 3: Биелэлт дутуу.</p> <p>Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх гарын авлагыг 2018 онд боловсруулсан. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд тус гарын авлагыг боловсруулж, сургагч багшийг дадлагажуулах сургалтын материалыг бэлтгэхэд ашигласан ч, MUGCUP2 төслийн хүрээнд зохион байгуулсан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургалтуудад гарын авлагыг ашиглаагүй болно.</p> <p>Шалгуур үзүүлэлт 5: Биелсэн.</p> <p>Хотыг дахин хөгжүүлэх төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс НЗДТГ-ын холбогдох байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох саналыг боловсруулсан.</p>

Тайлбар: Дээрхээс бусад Шалгуур үзүүлэлт нь Дэд төсөл 1-ийн шалгуур үзүүлэлтүүдэд хамаарна.

3. Төслийн загварын матрицад (ТЗМ) өөрчлөлт оруулсан байдал

Төслийн удирдах хорооны 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн 4-р хуралдаан, 2017 оны 6-р сарын 8-ны өдрийн 6-р хуралдаан болон 2018 оны 5-р сарын 25-ны өдрийн 7-р хуралдаанаар MUGCUP2 төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор ТЗМ-д оруулсан өөрчлөлтийг дараах хүснэгтэд үзүүлэв. Илүү дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас үзнэ үү.

Хурлын тэмдэглэл	Гарын үсэг зурсан он сар өдөр	Дэд төсөл 2-тэй холбогдолтой өөрчлөлт
ТУХ-ны 4-р хурлын тэмдэглэл	2016 оны 4-р сарын 27	<ul style="list-style-type: none"> Үр дүн 6-д Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг боловсруулах талаар нэмж оруулсан. Үүнээс үүдэн гурван үйл ажиллагаа нэмэгдсэн. Үр дүн 7-г тодруулсан. Үр дүн 5 болон 9-д зарим үйл ажиллагааг нэмж оруулсан: Үйл ажиллагаа 5-3: 'Орон нутагт хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл байдал, тулгарч болох

Хурлын тэмдэглэл	Гарын үсэг зурсан он сар өдөр	Дэд төсөл 2-тэй холбогдолтой өөрчлөлт
		<p>асуудлуудыг судлах (төслийн 3 төрлөөр)'; Үйл ажиллагаа 9-2: 'Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад санал, зөвлөмж өгөх'; Үйл ажиллагаа 9-3 'УИХ-аар батлагдах Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөлд санал, зөвлөмж өгөх'; ба Үйл ажиллагаа 9-5 'Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхэд санал, зөвлөмж өгөх (Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төсөл)'. • Үйл ажиллагаа 5-1, 5-2 болон 9-4-т нэр томъёоны бага зэргийн өөрчлөлт оруулсан.</p>
ТУХ-ны 6-р хурлын тэмдэглэл	2017 оны 6-р сарын 8	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа 7-2, 9-3-г тодруулсан. • Дор дурдсан үйл ажиллагааг хассан. Үүнд: Үйл ажиллагаа 8-4: 'Загвар төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах)'; Үйл ажиллагаа 9-4: 'НИТХ-аар батлагдсан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах (төслийн 3 төрлөөр)'; Үйл ажиллагаа 9-7: 'Төсөл төлөвлөх болон хэрэгжүүлэх үйл явцыг стандартчилах (төслийн 3 төрлөөр)'; болон Үйл ажиллагаа 9-8: 'Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг санал болгох (төслийн 3 төрлөөр)'. • Үйл ажиллагаа 11-9 ба 10-ыг нэмж оруулсан. Үүнд: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах • Төслийн зорилтын бодит шалгуур үзүүлэлт 4-ийг шинэчлэн өөрчилсөн ба шалгуур үзүүлэлт 5-ыг нэмсэн. Үр дүн 6, 7, 8, 9 ба 10-ын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн өөрчилсөн. Үр дүн 11-т шинэ шалгуур үзүүлэлтийг нэмсэн. • Үр дүнд баталгаажуулалтын зарим аргыг нэмсэн. • Ерөнхий зорилго, төслийн зорилтын хувьд "Төслийн хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйл"-ийг нэмж оруулсан болно. Нөлөөлөх хүчин зүйл 1-ийг шинэчилсэн.
ТУХ-ны 7-р хурлын тэмдэглэл	2018 оны 5-р сарын 25	<ul style="list-style-type: none"> • Төслийн зорилгын 3-р шалгуур үзүүлэлтийг шинэчилсэн.

4. Бусад

(1) 4-1 Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үр дүн (хэрэв байгаа бол)

Ангилал	Ангилал С
Ангиллын шалтгаан	Энэхүү төсөл нь хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах тул урьдчилсан үнэлгээ хийх үе шатанд байгаль орчинд нөлөөлөл нөлөөлөл байхгүй гэж үзсэн.

(2) 4-2 Жендер/энх тайван/ядуурлыг бууруулахад үзүүлэх үр дүн (хэрэв байгаа бол)

MUGCUP2 Төслийн баг ядуурлыг бууруулах асуудалд анхаарал хандуулан ажилласан. Учир нь гэр хорооллын ихэнхи иргэдийн орлогын түвшин өрхийн сарын орлогын шатлалын 30 хувиас доогуур байгаа ба өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны бодлогыг бага орлоготой өрхүүд тодорхойлдог. Орон сууцны эрэлт нийлүүлэлтийн хэтийн төлвийн хамт орон сууцны зах зээлийн судалгааг хийсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газарт бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг боловсруулан санал болгосон болно.

III. Хамтарсан үнэлгээний үр дүн

1. ДАС үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн үнэлгээний үр дүн

(1) Хамаарал

ЖАЙКА-гийн төслийг Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт үндэслэн эхлүүлсэн бөгөөд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-р хэсэгт хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар тусгагдсан нь хамаарал өндөр болохыг илтгэж байна. Түүнчлэн, НИТХ хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг тусгасан "Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг 2018 оны 2-р сард баталсан.

(2) Үр өгөөж

II хэсгийн 2-2-т тусгасанчлан төслийн үр өгөөжийг их гэж үзэж байгаа ч, төслийн зарим үйл ажиллагааг хараахан гүйцэтгэж дуусгаагүй байна. Үүнд:

ЖАЙКА-гийн төслийн хоёр үйл ажиллагаа бүрэн гүйцэд хийгдээгүй. Нэгдүгээрт, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийн үйл ажиллагаа (Үйл ажиллагаа 8-3) төлөвлөлтийн шатандаа зогссон. ЖАЙКА-гийн

төслийн баг 2 загвар төслийн эхний хувилбар болон нэгж талбарыг өөрчлөн зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж, уулзалт, сургалтуудаар дамжуулан төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагад дээрх төлөвлөгөөнүүдийн ач холбогдлын талаар танилцуулж байсан боловч НЗДТГ нь гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төсөл хэрэгжүүлэх газарт амьдарч буй иргэд оршин суугчидтай уулзахгүй ялангуяа хувь нийлүүлсэн талбайн талаар тайлбарлан таниулахгүй байсан. Хоёрдугаарт Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журмыг боловсруулан, батлуулах ажил (Үйл ажиллагаа 9-1) удааширсан ба Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах долоон дүрэм, журмын нэг болох гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журмын төсөл харахан батлагдаагүй байна. Тус журмын төслийг эхний байдлаар боловсруулсан байгаа ба ЖАЙКА-гийн төсөл дуусах үетэй зэрэгцэн эцэслэн боловсруулж, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Мөн гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны танилцуулга материал болон мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагад журмын төслийг тусгасан. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийг хэрэгжүүлэхийн тулд энэхүү журмыг төслийн эхэн үед боловсруулж, батлуулах шаардлагатай байсан. Энэ нь Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газраас гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийг хэрэгжүүлээгүйн шалтгаан болсон ч, удахгүй батлуулах журмын дагуу төслүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Нөгөө талаар загвар төслийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирсны улмаас ЖАЙКА-гийн Төслийн баг (ЖТБ) 2017 оны 6-р сарын 8-ний өдрийн ТУХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургалтын модулийг бий болгох болон сургагч багшид зориулсан сургалт зохион байгуулах ажлуудыг (Үйл ажиллагаа 11-9 ба 11-10) нэмж оруулахаар санал болгосон. Түүнчлэн, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургалтын модулийг мэргэшүүлэх сургалтын (сертификаттай) бүрэлдэхүүний нэг хэсэг болгосон. Сургалтын модулийг үргэлжлүүлэн боловсруулах нь хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлж буй мэргэжилтэн, албан хаагчдын чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах болно. Мөн сургагч багш болсон 20 гаруй мэргэжилтнүүд нь олж авсан мэдлэгээ хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зохион байгуулах иргэдтэй хийх уулзалт зэрэгт ашиглах боломжтой.

(3) Үр ашиг

Төслийн үр ашиг дундаж. Төсөл хэрэгжүүлэх зардал анх төлөвлөж байснаас давсан ч, төслийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлсэн.

	Төлөвлөсөн (Ex-ante судалгаанд үндэслэсэн)	Бодит
Хугацаа	2014 оны 9-р сар – 2018 оны 12-р сар (нийт 52 сар)	2015 оны 2-р сар – 2019 оны 1-р сар (нийт 47 сар)
Төслийн зардал*	340 сая Японы иен	439.73 сая Японы иен

Тайлбар: “ * ” тэмдэглэгээтэй дүнд Дэд төсөл 1 болон 2-ын зардал багтсан.

Төслийн үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэхэд төлөвлөж байснаас илүү хугацаа шаардагдсан хэдий ч, дийлэнх ажлыг төлөвлөсөн хугацаанд дуусгасан. Үйл ажиллагаануудыг тухайн үеийнх нь нөхцөл байдалтай уялдуулж, өөрчилж байсан. Мөн зарим үйл ажиллагааг нөхцөл байдалтай нийцэхгүй байсан тул хасч, хэд хэдэн үйл ажиллагааг шинээр нэмсэн. MUGCUP2 төслийг хэрэгжүүлэх хугацаанд төслийн зардал 61.16 сая иенээр нэмэгдсэнийг дараах хүснэгтээс харна уу. Ийнхүү нэмэгдсэн нь мэргэжилтнүүдийн ажиллах хүн/сарыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Хугацаа	Дүн (Японы иен)	Шалтгаан
2015 оны 12-р сар	36.08 сая	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн тогтолцоо хариуцсан төслийн ахлагч ба дэд ахлагч, мөн газар дахин зохион байгуулах төсөл, төслийн санхүүжилт, орон сууцны санхүүжилтийн тогтолцоо болон төслийн зардлын дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтнүүдийн хүн/сарыг дараах шалтгаанаас үүдэн нэмэгдүүлж, Монгол Улсад ирж ажиллах тоог нэмсэн. Төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагаас орон нутагт хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудад дүн шинжилгээ хийх, Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлого боловсруулах зэрэг ажлуудыг төслийн үйл ажиллагаанд нэмэх хүсэлтийг 2015 оны 6-р сард хуралдсан ТУХ-ны 3-р хурлаар хэлэлцүүлсэн. (Эдгээр ажлуудыг 2016 оны 4-р сард хуралдсан ТУХ-ны 4-р хурлаар баталсан төслийн ТЗМ-д тусгасан.)
2016 оны 3-р сар	2.85 сая	Үр дүн 6 буюу Улаанбаатар хотын бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлого боловсруулах үйл ажиллагааг 2015 оны 6-р сард хуралдсан ТУХ-ны 3-р хурлаар баталж, нэмсэнтэй холбогдуулан төслийн санхүүжилт, орон сууцны санхүүжилтийн тогтолцоо хариуцсан мэргэжилтний хүн/сарыг дараах шалтгаанаас үүдэн нэмэгдүүлж, Монгол Улсад ирж

Хугацаа	Дүн (Японы иен)	Шалтгаан
		ажиллах тоог нэмсэн. (Тус үйл ажиллагааг 2016 оны 4-р сард хуралдсан ТУХ-ны 4-р хурлаар баталсан төслийн ТЗМ-д тусгасан.) Төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагаас бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг сууцны төрлөөр боловсруулж, холбогдох байгууллагуудад танилцуулах хүсэлтийг ЖАЙКА-гийн төслийн багт тавьсан.
2017 оны 8-р сар	22.23 сая	ЖАЙКА болон ЖАЙКА-гийн төслийн багийн хооронд байгуулсан 2-р дахь гэрээний хугацаанд ажиллах бүх мэргэжилтнүүдийн хүн/сарыг дараах шалтгаанаас үүдэн нэмэгдүүлж, Монгол Улсад ирж ажиллах тоог нэмсэн. 2017 оны 6-р сард хуралдсан ТУХ-ны 6-р хурлаар төслийн үйл ажиллагааг II хэсгийн 3-т заасны дагуу дүгнэсэн. Зарим ажлыг хэрэгжүүлэх хугацаа сунжирсан, төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц өөрчлөгдөж, мэргэжилтнүүд нь солигдсон зэргээс үүдэж зарим үйл ажиллагаануудад өөрчлөлт орсон.

(4) Үр нөлөө

Төслийн Үр нөлөө (ЖАЙКА-гийн төслийг хэрэгжүүлж дууссаны дараа гурван жилийн хугацаанд ерөнхий зорилгод хүрэх) их байсан.

ЖАЙКА-гийн төслийн зорилгод хүрэхийн тулд дараах үр дүнгүүдийг хэрэгжүүлсэн. Эдгээр үр дүнгүүд нь хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг дэмжих, цаашлаад төслийн ерөнхий зорилгод хүрэхэд чиглэгдсэн.

- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль УИХ-аар батлагдсан.
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журмуудыг боловсруулж, батлуулсан.
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх сургалтын модулийг бий болгож, мэргэшүүлэх сургалтын (сертификаттай) бүрэлдэхүүний нэг хэсэг болгосон.
- Сургагч багш нарыг бэлтгэсэн.
- НИТХ-аар "Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөр батлагдсан.
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, ашиглалтын шаардлага

хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах болон гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны иргэдэд зориулсан танилцуулга видео, товхимлыг боловсруулсан.

- Төсөл дуусахтай зэрэгцүүлээд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагыг боловсруулж дуусгана.

Түүнчлэн ЖАЙКА-гийн төслийн багийн санал болгосон бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлого нь гэр хорооллын оршин суугчид байшин сууцаа шинэчлэн барих, байшин сууцныхаа нөхцөлийг сайжруулан, инженерийн шугам сүлжээнд холбох зэрэгт дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой юм. Энэхүү бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлого нь гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа болно. БХБЯ тус бодлогыг хэрэгжүүлэх талаар судалж эхлээд байна.

(5) Тогтвортой байдал

Тогтвортой байдал буюу төсөл хэрэгжиж дууссан ч, цаашид үйл ажиллагаа нь хэрэгжих боломж дунд зэрэг байна.

1) Бодлого, институцийн асуудал

Төсөл хэрэгжих хугацаанд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар баримталж буй ерөнхий бодлого өөрчлөгдөөгүй, хэвээр байсан. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эхэлсэнтэй холбогдуулан гэр хорооллыг дахин төлөвлөж, хөгжүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгыг дахин төлөвлөж барилгажуулах зэрэг чухал асуудлуудад ач холбогдол өгөх шаардлагатай. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчин улам боловсронгуй болж буй өнөө үед дахин хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжих асуудлыг авч үзэх нь чухал.

2) Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц

2013 онд Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар (НГХДБГ) нийслэлийн гэр хорооллыг дахин төлөвлөх, хөгжүүлэх чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. Тус газрыг байгуулсан нь гэр хорооллыг хөгжүүлэх нь нийслэлийн тэргүүлэх ач холбогдолтой ажлын нэг болохыг харуулж байна.

ЖАЙКА-гийн төслийн баг НГХДБГ-ын үйл ажиллагааг сайжруулах боломж бий гэж үзсэн. Тийм учраас төслийн баг НГХДБГ-ын хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын хүрээнд төсөл тус бүрийг хариуцсан “Төслийн менежментийн нэгж”-ийг ажиллуулах саналыг боловсруулж, танилцуулсан. Төслийн менежментийн нэгж нь төслийн бүх үе шатанд хэрэгжилтийг хянах ба тухайн төсөлтэй холбоотой үйл ажиллагаа бүрийг хариуцсан мэргэжилтэн тодорхой болсон байна. НГХДБГ ЖАЙКА-гийн төслийн багийн боловсруулсан саналыг судалж, хэрэгжүүлснээр хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн хэрэгжилт илүү үр дүнтэй болно гэж үзэж байна.

3) Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын чадавхийн асуудал

Хамтран ажиллагч байгууллагууд ялангуяа Гэр хорооллын дэд бүтцийн газрын мэргэжилтнүүдийн хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чадавхи хангалтгүй хэвээр байна. Төрөөс мониторинг хийх чадавхи сул байгаагийн зэрэгцээ төсөл гацсан тохиолдолд шаардлагатай хариу арга хэмжээ авахад хүндрэл бэрхшээл тулгардаг.

Гэсэн хэдий ч хот, суурин газрыг дахин хөгжүүлэх сургалтын модулаар дамжуулан мэргэжилтнүүдэд мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг олгох найдлага байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх сургалтын модулийг гарын авлага болон мэргэшүүлэх сургалтын (сертификаттай) бүрэлдэхүүний нэг хэсэг болгон боловсруулсан бөгөөд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулж буй мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлнэ. Энэхүү үйл явцын үеэр хамтран ажиллагч байгууллагуудын мэргэжилтнүүд сурталчилгааны материал, гарын авлага ба сургалтын материал боловсруулахад гар бие оролцсон бөгөөд лекц уншсан болно. Тэд эдгээр үйл ажиллагаануудын үр дүнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх ойлголтоо гүнзгийрүүлсэн. Одоо тэд сургагч багшийн хувиар сургалтууд зохион байгуулахаар төлөвлөж байна. Ингэснээр мэргэжилтнүүдэд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдлэгээ өргөжүүлэх боломж бүрдэнэ.

4) Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн асуудал

Нийслэлийн зүгээс хоёр жилийн хугацаанд 50 дэд бүтцийн төвийг барьж байгуулахаар төлөвлөсөн. Ирэх онд таван дэд бүтцийн төвийг барьж байгуулахын тулд дэд бүтцийн төв тус бүрт 10 тэрбум төгрөгийг төсөвт суулгах шаардлагатай. Нийслэл дэд бүтцийн төв барьж байгуулах төслийн нэг

хэсэг болгон гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаа ба ЖАЙКА-гийн төслийн баг тус хоёр төслийг хамтад нь хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй гэж үзэж байна.

2. Хэрэгжилтэнд нөлөөлж буй гол хүчин зүйлс ба үр дүн

(1) Бодлогын асуудал

УИХ-ын 2016 оны сонгуулийн үр дүн ЖАЙКА-гийн төсөлтэй хамтран ажиллагч байгууллагуудын хүний нөөц болон нийслэлээс баримталж буй бодлогод ихээхэн нөлөө үзүүлсэн. Нийслэлийн зүгээс Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн дагуу хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон үед ЖАЙКА-гийн төслийн үйл ажиллагаа эхэлсэн. НЗДТГ нь НИТХ-ын 2013 оны 3/31-р тогтоолоор баталсан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”-ын дагуу гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Түүний дараа НИТХ-ын 2014 оны 90-р тогтоолоор баталсан “Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах журам”-ын дагуу ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслүүдийг хэрэгжүүлсэн. ЖАЙКА-гийн төсөл хэрэгжиж эхэлсний дараа Гэр хорооллыг орон сууцжуулах төслийн мэргэжилтнүүд Төслийн багийн дэмжлэгтэйгээр Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байсан.

2016 оны сонгуулийн дараа Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдаж, нийслэлийн байгууллагуудын бүтэц өөрчлөгдсөн ба Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны шинэ үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-р хэсэгт хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа тусгагдсан байдаг. Шинээр эмхлэн байгуулагдсан НЗДТГ нь ЖАЙКА-гийн төслийн ТЗМ-д тусгасан бие даасан инженерийн дэд бүтцийн төлөвлөлт болох гэр хороололд дэд бүтэц барьж байгуулах ялангуяа дэд бүтцийн төв байгуулах төсөлд анхаарлаа хандуулсан. Загвар төслийг Чингэлтэй дүүргийн 7-р хороо болон Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхээр сонгосон бөгөөд тус дэвсгэр газарт гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг дэд бүтцийн төв байгуулах төсөлтэй хамтатган хэрэгжүүлэх шаардлагатай байв. Гэвч эхлээд дэд бүтцийн төв байгуулах төслийг хэрэгжүүлсэн ба гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлэх төсөв батлагдаагүйн улмаас загвар төсөл хэрэгжиж эхлээгүй.

ЖАЙКА-гийн төслийн баг нь Гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нарт болон мэргэжилнүүдэд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар үргэлжлүүлэн тайлбарласаар байсан. Мөн ЖАЙКА-гийн төслийн багийн зүгээс НЗДТГ-аас гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар БХБЯ-тай цөөнгүй удаа зөвлөлдсөн ч, тэд шаардлагатай арга хэмжээг авч чадаагүй.

(2) Институцийн асуудал

УИХ-ын 2016 оны сонгуулийн үр дүнд шинэ Засгийн газар эмхлэн байгуулагдсаны улмаас хамтран ажиллагч байгууллагуудын хувьд төсөл хэрэгжүүлэх хугацаанд тогтвортой бус байсан. ЖАЙКА-гийн төсөл хэрэгжүүлж эхэлсэнээс дуусах хүртэлх бүхий л хугацаанд Ажлын хэсгийн 27 гишүүнээс зөвхөн 8 нь өөрчлөгдөлгүй хамтран ажилласан бол харин ТУХ-ны хувьд нэг ч албан тушаалтан байгүй байна.

Төсөл хэрэгжүүлэх хугацаанд хамтран ажиллагч байгууллагуудын шийдвэр гаргагч түвшний албан тушаалтнууд байнга өөрчлөгдөж байсан. Жишээлбэл төслийн хамгийн гол хамтран ажиллагч БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга үүрэг гүйцэтгэгчийг тооцвол таван удаа өөрчлөгдөн солигдсон. Тэд томилогдсоныхоо дараа өөрсдийн хариуцсан ажлын улмаас ЖТБ-ийн гишүүдтэй хамтран ажиллах цаг завгүй байсан.

Төслийн үйл ажиллагаа удааширсан нэг гол шалтгаан бол УИХ-ын 2016 оны сонгуулийн үр дүнд төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, албан тушаалтнууд нэн ялангуяа нийслэлийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, албан тушаалтнууд ихээхэн өөрчлөгдсөн явдал юм. Байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах үйл явц нилээдгүй цаг хугацаа авсан. Энэ нь ЖАЙКА-гийн төсөлтэй хамтран ажиллах Ажлын хэсгийн гишүүдийг шинээр томилох ажлыг удаашруулахад хүргэсэн. УИХ-ын сонгууль болсоноос хойш есөн сарын дараа 2017 оны 3-р сарын 23-нд Ажлын хэсгийн анхны хурлыг хуралдуулсан.

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах болон гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байсан Гэр хорооллын хөгжлийн газар болон Гэр хорооллыг орон сууцжуулах төслийг нэгтгэн Гэр хорооллын дэд бүтцийн газрыг байгуулсан. Энэхүү шинээр байгуулагдсан газрын мэргэжилтэн, албан тушаалтнуудын ихэнхи нь шинээр томилогдсон бөгөөд тэдгээрийн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай

хууль, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа болон хот байгуулалтын тухай ерөнхий ойлголт муу байсан.

Загвар төслийн байршлыг сонгох (Үйл ажиллагаа 8-1) үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүртэл ЖАЙКА-гийн төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш хоёр жилийн хугацаа шаардагдсан. Тиймээс ТУХ-ны 2017 оны 6-р сарын хуралдаанаар ТЗМ-д өөрчлөлт оруулж, “загвар төслийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх” үйл ажиллагааг хассан. Учир нь УИХ-ын 2016 оны сонгуулийн дараа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэн өөрчлөгдөж, өмнө нарийвчлан судалсан байсан гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслүүдийг хэрэгжүүлэх байршлыг өөрчилсөн. Мөн нийслэлийн байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагаа болон загвар төслийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргахад ихээхэн цаг хугацаа зарцуулсан. Энэхүү ТУХ-ны хурлын дараа ч загвар төслийн төлөвлөгөө (Үйл ажиллагаа 8-3) боловсруулах, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журам боловсруулах (Үйл ажиллагаа 9-1) болон сургагч багшид зориулсан сургалтыг зохион байгуулах (Үйл ажиллагаа 11-9 ба 11-10) үйл ажиллагаанууд маш удаан явагдсан.

Мөн Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журмыг боловсруулан, батлуулах ажил удааширсан нь төслийн үр ашигт сөрөг нөлөө үзүүлсэн. Энэ нь гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны сурталчилгааны материал бэлдэх (Үйл ажиллагаа 10-4) болон мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага боловсруулах (Үйл ажиллагаа 9-6) ажлыг удаашруулахад хүргэсэн. Үүнээс үүдэн сурталчилгааны материал болон гарын авлагыг загвар төслийн төлөвлөлт болон сургалтуудад сайтар ашиглаж чадаагүй.

2014 оны 10-р сарын хурлын тэмдэглэлд тусгаснаар Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах долоон дүрэм, журмын төслийг 2015 оны 12-р сард боловсруулж дуусгахаар төлөвлөсөн байсан. БХБЯ нь ЖАЙКА-гийн төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш хагас жилийн дараа буюу 2015 оны 10-р сарын 19-нд дүрэм, журмын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Түүний дараа Ажлын хэсгийн гишүүдийг 2016 оны 10-р сард, 2017 оны 2-р сард, 2017 оны 8-р сард болон 2018 оны 4-р сард дөрвөн удаа тус тус өөрчилсөн болно. (Хавсралт 1 (2) 3-ыг үзнэ үү). ЖТБ-ийн зүгээс тэр болгонд шинэ танилцуулга хийн, хийсэн ажлаа давтаж байсан. 2018 оны 12-р сарын 5-ны байдлаар Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журмын төслийг эхний байдлаар боловсруулаад байна.

Хамтран ажиллагч байгууллагуудын мэргэжилтнүүд, Ажлын хэсгийн гишүүд байнга өөрчлөгддөгтэй холбоотойгоор ЖТБ-ийн зүгээс явуулж буй үйл ажиллагаа болон сургалтын агуулга байнга давтагдсан. Эерэг тал нь гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны талаар олон мэргэжилтнүүд сурч мэдсэн болно. Харин сөрөг тал нь ЖТБ-ийн зүгээс төсөл эхлэх үед төсөөлж байсан гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны талаарх гүн бат мэдлэгийг холбогдох мэргэжилтнүүд олж авч чадаагүйд оршино.

(3) Мэргэжлийн асуудал

Дээр дурьдсанаар хамтран ажиллагч мэргэжилтнүүд байнга солигдон өөрчлөгдөж байсны улмаас ижил сургалтыг дахин дахин давтан хийх шаардлагатай болсон. Тиймээс мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг алхам алхмаар сайжруулахад бэрхшээлтэй байсан.

(4) Санхүүгийн асуудал

2018 оны улсын болон нийслэлийн төсөвт Чингэлтэй дүүргийн 7-р хороо болон Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт загвар төсөл хэрэгжүүлэх төсөв хөрөнгийг баталгаажуулаагүй боловч тухайн нутаг дэвсгэрт дэд бүтцийн төв барьж байгуулах төслийн төсвийг тусгасан. Энэ нь төслийн зорилгын чухал үйл ажиллагааны нэг нь хангалтгүй байна гэсэн үг юм.

3. Төслийн эрсдэлийн менежментийн үр дүнгийн үнэлгээ

Өмнөх хэсэгт (1) Бодлогын асуудал ба (4) Санхүүгийн асуудалд дурьдсанаар ЖТБ нь Нийслэлийн Засаг даргын орлогчтой уулзаж, загвар төслүүдийн байршилд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлэх боломжийн талаар хэлэлцсэн. 2018 оны 2-р сарын 9-нд хурлын үеэр Нийслэлийн Засаг даргын орлогч тус асуудлыг зөвшөөрч, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан болно.

Нийслэлээс Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авахгүй байсан тул ЖТБ-ийн зүгээс 2018 оны 3-р сарын 26-ны өдөр шаардлагатай арга хэмжээ авахыг хүссэн албан бичиг илгээсэн. Тэрхүү албан бичгийн хариу 2018 оны 5-р сарын 25-нд ТУХ-ны хурлыг зохион байгуулахын өмнөхөн ирсэн. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн хариу ирүүлсэн. Тус албан бичигт НИТХ-аар загвар төслийн талбайн хил хязгаарыг батлуулах тухай болон оршин суугчидтай уулзалт зохион байгуулж, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн төлөвлөгөөг танилцуулах

тухай тусгасан байсан.

ЖТБ-ийн зүгээс Чингэлтэй дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэр ба Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх загвар төслийн төлөвлөгөөний төсөл болон нэгж талбаруудыг өөрчлөн зохион байгуулах төлөвлөгөөний эхний төслийг тус тус боловсруулсан. Гэр хорооллын дэд бүтцийн газрын захирал, хэлтсийн дарга нар, холбогдох мэргэжилтнүүдийг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу шаардлагатай үйл ажиллагаа явуулахыг урамшуулан дэмжих үүднээс тус төлөвлөгөөний төслүүдийг үргэлжлүүлэн тайлбарласаар байсан. ЖТБ нь Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт барьж байгуулах дэд бүтцийн төвийн төсвийн хуваарилалтыг хариуцсан БХБЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх загвар төслийн төлөвлөгөөний төсөл болон нэгж талбаруудыг өөрчлөн зохион байгуулах төлөвлөгөөний төслийн талаар тайлбарласан. Гэвч БХБЯ болон Гэр хорооллын дэд бүтцийн газар 2018 оны 10-р сар хүртэл ямар нэгэн арга хэмжээ аваагүй болно. ЖАЙКА-гийн төслийн зүгээс 2018 оны 10-р сарын 24-ний өдөр БХБЯ-ны Дэд сайд болон Нийслэлийн Засаг даргын орлогчид арга хэмжээ авахыг хүссэн албан бичиг дахин илгээсэн. НЗДТГ-аас 2018 оны 11-р сарын 20-ны өдөр албан бичгийн хариу ирсэн бөгөөд түүнд Гэр хорооллын дэд бүтцийн газар нь гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн төлөвлөгөөний төсөл болон нэгж талбаруудыг өөрчлөн зохион байгуулах төлөвлөгөөний төслийг 2019 оны үйл ажиллагаандаа зөвлөмж болгон ашиглахаа илэрхийлсэн болно.

Өмнөх хэсэгт (2) Институцийн асуудал ба (3) Мэргэжлийн асуудалд дурьдсанаар ЖТБ нь БХБЯ болон ГЗБГЗЗГ-тай хамтран Гэр хорооллын дэд бүтцийн газрын мэргэжилтнүүдэд зориулан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар цуврал сургалтуудыг зохион байгуулсан. Түүнчлэн ЖТБ нь БХБЯ-ны офисын өрөөнөөс гадна 2016 оны 11-р сарын дунд үеэс эхлэн мэдлэг туршлагаа хувааалцах үүднээс Гэр хорооллын дэд бүтцийн газарт офисын өрөөтэй болсон. Энэ нь ЖТБ болон Гэр хорооллын дэд бүтцийн газар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулсан.

Үүнээс гадна УИХ-ын 2016 оны сонгуулийн дараа бий болсон шинэ бүтэц болон мэргэжилтнүүдэд зориулж 2017 оны 2-р сарын 5-18-ны өдрүүдэд Япон улсад сургалт зохион байгуулж, хамтран ажиллагч байгууллагуудын шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг урин оролцуулсан. Сургалт үр дүнтэй байсан ба сургалтын дараа хамтран ажиллагч байгууллагын мэргэжилтэн, албан тушаалтнуудын санал, бодол ихээхэн өөрчлөгдсөн. Сургалтанд хамрагдагсдын

ЖАЙКА-гийн төсөл болон хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх ойлголт сайжирсан. Хамтран ажиллагч байгууллагуудын ЖАЙКА-гийн төслийн багийн үйл ажиллагаанд оролцох оролцоо мэдэгдэхүйц нэмэгдсэн.

Гэсэн хэдий ч эдгээр хүчин чармайлт удаан үргэлжилсэнгүй. Гэр хорооллын дэд бүтцийн газрын албан тушаалтнууд нь дэд бүтцийн төвийг барьж байгуулах төсөл хэрэгжүүлэхээр завгүй ажиллаж байсан бөгөөд тэдний ажил үүргийн хуваарьт тусгагдаагүй гэж үзэн ЖАЙКА-гийн төслийн үйл ажиллагаанд цаг зав зарцуулахгүй байсан. Түүнээс гадна 2017 оны эцсээр захирал нь мөн 2018 оны 7-р сард гол хэлтсийн дарга нь албан тушаалаас чөлөөлөгдсөн ба шинээр томилох явц удаан үргэлжилсэн нь тэдний үйл ажиллагааг удаашруулсан.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төсөл боловсруулах үйл явц УИХ-ын сонгууль хүртэл хэвийн явагдсан. Төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам, Төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам болон Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын төслийг боловсруулж, батлуулсан. Гэвч УИХ-ын 2016 оны сонгуулийн дараа дүрэм, журмын төсөл боловсруулах үйл ажиллагаа удааширсан. ЖТБ нь ТУХ-ны хурлуудын үеэр гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төсөл хэрэгжүүлэх, сурталчилгааны материал бэлдэх болон мэргэжилтнүүдэд зориулсан гарыг авлага боловсруулахад эдгээр дүрэм, журмуудын төслийг аль болох эрт боловсруулах нь чухал ач холбогдолтойг удаа дараа тайлбарлан ажлаа эрчимжүүлэхийг хүссэн. 2017 оны 6-р сар болон 2018 оны 5-р сард хуралдсан ТУХ-ны хурлын тэмдэглэлд дүрэм, журмуудын төсөл боловсруулах ажлыг түргэвчлэн, дуусгах талаар тусгагдсан болно. Гэвч эдгээр хурлын шийдвэр төдийлөн тус болоогүй ба УИХ-ын сонгуулиас 2 жилийн дараа буюу 2018 оны 7-р сард Нөхөх олговор олгох журмын төсөл болон 2018 оны 11-р сард Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журмын төсөл тус тус батлагдсан.

Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслүүд хэрэгжээгүй тул хамтран ажиллагч байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх талаар ТЗМ-д тусгасан төслийн зорилгыг биелүүлэхэд хүндрэлтэй байв. ЖТБ нь 2017 оны 6-р сарын ТУХ-ны хуралдаанаар төслийн үйл ажиллагаанд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар сургалт явуулах, сургагч багш нарыг бэлтгэх ажлыг нэмж оруулахаар санал болгосон. Гэвч шийдвэр гарсанаас хойш арван сарын дараа 2018 оны 4-р сард сургалтын бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг

байгуулсан. Сургагч багш нарыг сургалтанд хамруулсан боловч цаг хугацаа хязгаарлагдмал байсны улмаас сургалтын чанар хангалтгүй байсан. Гэр хорооллыг орон сууцжуулах төсөлд ажиллаж байснаа хожим нь ЖАЙКА-гийн төслийн багийн гишүүнээр ажилласан хоёр мэргэжилтэн нь л гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн төлөвлөлт болон нэгж талбаруудыг өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагааны талаар бүрэн гүйцэд тайлбарлах чадвартай байна.

4. Авсан сургамж

(1) ЖАЙКА-гийн төсөл боловсруулах явцад загвар төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг баталгаажуулах

ТЗМ-ын төслийн урьдчилсан нөхцөл болон хүлээсэн чухал үүргийн нэг нь "Монголын тал төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг хуваарилна" мөн "Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хот байгуулалтын төслүүдэд төсөв хуваарилна" гэж тус тус тусгасан болно. Гэвч энэ асуудлыг Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тодруулан оруулаагүй. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийг 2018 ба 2019 оны төсөвт ч суулгаагүй, баталгаажуулаагүй байна. Монголын талаас загвар төслийн байршлыг сонгоогүй, хэрэгжүүлээгүй хамгийн гол шалтгаан нь төсөвт хөрөнгө мөнгө суулгаагүйтэй холбоотой юм.

Загвар төслийг зохих ёсоор хэрэгжүүлэх үүднээс ЖАЙКА-гийн төслийг боловсруулах үе шатанд загвар төсөл хэрэгжүүлэх төсвийг баталгаажуулан, Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгах шаардлагатай байсан. Загвар төсөл хэрэгжүүлэх төсвийг баталгаажуулаагүй тохиолдолд ЖАЙКА-гийн төслийг түдгэлзүүлэх нөхцөлийг тодруулан оруулах нь зүйтэй байжээ.

Түүнчлэн ЖАЙКА-гийн төслийг боловсруулах үед загвар төслийг хэрэгжүүлэх нийслэлийн төсвөөс гадна санхүүгийн боломжит зохицуулалтыг авч үзэх шаардлагатай байсан. Учир нь Монгол Улсын Засгийн газар төсвийн дутагдалаар байнга шалтгалдаг тул ЖАЙКА-гийн төсөл эхлэхээс өмнө Монгол Улс болон Япон улс санхүүгийн бусад эх үүсвэрийн талаар хэлэлцэх шаардлагатай байв.

(2) Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс хамтран ажиллах байгууллагуудыг зохих ёсоор ажиллуулах талаарх хүсэлт

НЗДТГ-ын хувьд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслийг Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Хот дахин хөгжүүлэх хэлтэс, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл болон гэр хорооллын

газрыг дахин зохион байгуулах төслийг Гэр хорооллын дэд бүтцийн газар эрхлэн явуулж байна. Гэр хорооллын дэд бүтцийн газрын хариуцан ажиллаж буй сүүлийн хоёр төслийн хэрэгжилтэд хүндрэл учирч байна. ЖАЙКА-гийн Төслийн баг Гэр хорооллын дэд бүтцийн газарт хот төлөвлөлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардлагатай архитектор, газар зохион байгуулагч, хот төлөвлөлт/хот байгуулалтын мэргэжилтэн болон инженерүүд дутагдалтай байна гэж үзэж байна. Эдгээр мэргэжилтнүүд мөн шийдвэр гаргах түвшинд ч чухал хэрэгцээтэй байна. Төслийн багийн зүгээс тэдэнд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагаа, түүний ач холбогдол, ашиг тусыг ойлгоход хүндрэлтэй байж болох юм гэж үзэж байна. Нийслэлийн зүгээс тухайн байгууллагуудад архитектор, газар зохион байгуулагч, хот төлөвлөлт/хот байгуулалтын мэргэжилтэн, инженер болон бусад мэргэжилтнүүдийг томилон ажиллуулах нь маш чухал юм.

Үүний зэрэгцээ загвар төслийг хэрэгжүүлэх үндсэн гишүүдийг томилон ажиллуулах нь чухал. ЖАЙКА-гийн Төслийн баг загвар төслийг хэрэгжүүлэх төрөл бүрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн дэд Ажлын хэсгийг байгуулсан. Гэвч тус Ажлын хэсгийн гишүүд загвар төслийг шууд хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий албан тушаалтнууд биш тул тэдний бодит ажилд оролцох оролцоо хязгаарлагдмал байсан. Түүнчлэн УИХ-ын 2016 оны сонгуулиас өмнө хамтран ажиллагч мэргэжилтнүүд Гэр хорооллыг орон сууцжуулах төсөлд үргэлжлүүлэн ажиллах боломжтой байсан. Гэсэн хэдий ч сонгуулийн дараа Гэр хорооллын дэд бүтцийн газарт үндсэн гишүүдийг томилон ажиллуулаагүй. Загвар төслүүдийн хэрэгжилтийг хангахын тулд хамтран ажиллагч үндсэн гишүүдийг томилон ажиллуулах шаардлагатай байсан.

Дээр дурдсан асуудал хангалтгүй байсан гэж үзвэл “ЖАЙКА-гийн төслийн Монголын талын хамтран ажиллах байгууллагуудын мэргэжилтнүүдийг зохих ёсоор томилон ажиллуулна” гэсэн ТЗМ-ын төслийн урьдчилсан нөхцөлийг хангаагүй гэсэн үг юм. Энэ нөхцөл байдлаас зайлсхийх нэг боломжит шийдэл нь ЖАЙКА-гийн төслийг боловсруулах үе шатанд төслийн урьдчилсан нөхцөлийг хангаагүй тохиолдолд төслийг түдгэлзүүлэх нөхцөлийг тодорхой болгох явдал юм .

(3) Загвар төслийн үр дүнг нотлон үзүүлэхийн ач холбогдол

Монгол Улсад хүмүүс шинэлэг зүйлсийг хэрэгжүүлсэн сайн жишээг нүдээр харж байж, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх хандлагатай байдаг. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг нотлон үзүүлэхийн тулд загвар төслийг ЖАЙКА-ийн мэргэжилтнүүдийн хяналтын дагуу хэрэгжүүлэх нь маш

чухал байсан.

Засгийн газрын шийдвэр гаргагчдын гол ашиг сонирхол нь сонгогдсон дөрвөн жилийн хугацаандаа харагдахуйц төслийг хэрэгжүүлэх явдал юм. Гэвч гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хэрэгжүүлэхэд төслийг хэрэгжүүлэхийн өмнөх бэлтгэл үе шатанд болон төсөл хэрэгжүүлэх үе шатанд олон нийтийг оролцоог хангах, тэдэнтэй зөвшилцөлд хүрэх зэргээр ерөнхийдөө ихээхэн цаг хугацаа шаардагддаг. Тиймээс загвар төслүүдийг аль болох цомхоноор төлөвлөх хэрэгтэй. Энэ нь анхны туршлага тул удирдан, зохион байгуулахад дөхөмтэй бөгөөд төсөл хэрэгжүүлэх хугацаанд хэрэгжих боломжийг нэмэгдүүлнэ.

IV. ЖАЙКА-гийн төсөл хэрэгжиж дууссаны дараа ерөнхий зорилгод хүрэх

1. Ерөнхий зорилгыг биелүүлэх хэтийн төлөв

Төслийн ерөнхий зорилго болох “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт үндэслэн нийслэл хотын оршин суух нөхцөл, хотоос иргэдэд үзүүлэх үйлчилгээг хот байгуулалтын төлөвлөлтөөр дамжуулан сайжруулах” зорилгод тодорхой хэмжээнд хүрнэ гэж үзэж байна.

2018 оны хоёрдугаар сард НИТХ-аар "Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг баталсан бөгөөд энэхүү дэд хөтөлбөрийг Улаанбаатар хотын хотыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө гэж үзэж болох юм. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт нь (1) бага дунд орологотой иргэдэд зориулсан орон сууцыг хөгжүүлэх, (2) түрээсийн болон түр суурьших орон сууцыг хөгжүүлэх, (3) шинэ суурьшил, хорооллыг хөгжүүлэх, (4) хот, суурин газрыг дахин хөгжүүлэх зорилтот төслүүдийг хэрэгжүүлэх болон (5) дулаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цахилгааны шугам сүлжээг өргөтгөх, цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх болон ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх зэрэг болно. Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018-2022 онд таван жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр гарах үр дүн нь ЖАЙКА-гийн төслийн ерөнхий зорилготой ижил тул энэхүү дэд хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрвэл ЖАЙКА-гийн төслийн ерөнхий зорилго ч мөн биелэх болно. Түүнчлэн НЗДТГ нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг тодотгон Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлж байгаа бөгөөд энэ нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий

төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт, шинжилгээ хийх ажлаар эхлэх нь зүйтэй.

Төслийн хүрээнд Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт, шинжилгээ хийх БХБЯ болон НЗДТГ-ын хамтарсан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулаагүй бөгөөд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслүүдийг хэрэгжүүлж эхлээгүй. Гэвч хяналт шинжилгээний аргачлал болон загвар төслийн хэлэлцүүлгийн явцад олон тооны аргачлал, төлөвлөгөө боловсруулан санал болгож, хот, сууриныг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбогдолтой дүрэм журмыг боловсруулж, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх техникийн гарын авлагыг боловсруулсан болно. Эдгээр үйл ажиллагааны хүрээнд сургалтын гарын авлага болон сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлого боловсруулан санал болгосон бөгөөд ингэснээр хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслөөр дамжуулан бага орлоготой иргэдэд зориулсан орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг авч үзнэ.

Монгол Улс “Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт тодотгол хийх замаар ерөнхий зорилгод хүрнэ гэдэгт итгэлтэй байна. Үүнд ЖАЙКА-гийн төслийн инситуци болон чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа хувь нэмрээ оруулах нь эргэлзээгүй юм.

2. Ерөнхий зорилгод хүрэх Монголын талын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжүүлэх бүтэц

Монгол Улсын Засгийн газар ерөнхий зорилгод хүрэх үүднээс ЖАЙКА-гийн төсөл хэрэгжүүлэх хугацаанд хийж дуусгаагүй үйл ажиллагааг үргэлжлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

(1) Хууль, эрх зүйн орчин ба бодлого

- 1) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журмын төслийг эцэслэн боловсруулж, БХБ-ын Сайдын тушаалаар батлуулах
- 2) Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг тусгах

3) Аль болох улс төрийн хараат байдлаас хамааралгүйгээр хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох;

(2) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл

4) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх дүрэм журам болон хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаарх гарын авлагад үндэслэн газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчидтэй харилцан зөвшилцөж, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслүүдийг (СБД-ийн 18-р хороонд байршилтай төслийг оролцуулаад) хэрэгжүүлэх боломжийн талаар сайтар судлах

5) Нийслэл болон орон нутагт хэрэгжүүлэх гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслийн хөрөнгө, санхүүжилтийг төсөвт суулгах

6) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх дүрэм журмын дагуу гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдийн мэдээллийг шинэчилж, мэдээллийн дагуу хэрэгжилтийг нягтлан үзэж, үйл ажиллагааг нь цуцлах зэрэг шаардлагатай арга хэмжээг авах

7) Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдэд тогтмол хяналт шинжилгээ хийж, үнэлэлт өгөх гүйцэтгэлийн удирдлагаар хангах;

8) Хувийн компаниуд тендерт оролцохгүй байгаа тул ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслүүдийн хүрээнд түрээсийн орон сууцыг барьж байгуулах

(3) Мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх болон хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг сурталчлан, таниулах үйл ажиллагаа

9) ЖАЙКА-гийн төслийн багийн боловсруулсан гарын авлагыг ашиглаж, төслийн багийн зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан сургагч багш нарыг оролцуулан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах

10) Нийслэлийн холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдэд зориулж хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулах

11) Мэргэшүүлэх сургалтын хүрээнд сургалтад хамрагдсан сургагч багш нарын ажлын байрны тогтвортой байдлыг хангах, сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх

12) Төслийн хүрээнд хийгдсэн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, дүрэм журмын талаархи иргэдэд зориулсан гарын авлага, видео танилцуулгийг

иргэдэд түгээх сурталчлах ажлыг зохион байгуулах.

3. Монголын талд өгөх зөвлөмж

ЖАЙКА-гийн Төслийн багийн зүгээс Монголын талд дор дурдсан зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- (1) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны талаар болон Улаанбаатар хотод тус төслийг хэрэгжүүлэх боломжийн талаар нарийвчлан судлах. Харамсалтай нь ЖАЙКА-гийн төсөл хэрэгжүүлэх явцад хамтран ажиллагч байгууллагуудын гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны талаарх ойлголт хангалтгүй байсан. ЖТБ-ийн зүгээс загвар төслүүдийг хэрэгжүүлэх замаар гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааг нягтлан үзэж, өөрчлөн сайжруулах хүлээлттэй байсан. Гэвч сонгосон загвар төслүүдийг хэрэгжүүлээгүй тул энэхүү зорилгод хүрч чадсангүй. Тиймээс Монголын тал цаашид үргэлжлүүлэн судалж, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааг Монголын нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Шаардлагатай бол гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг дэд бүтцийн төв байгуулах төсөлтэй хэрхэн нэгтгэн хэрэгжүүлэх талаар судлах хэрэгтэй. Хэрэв уг төслийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзвэл оршин суугчдын хүсэл эрмэлзэлийг хүндэтгэн үзэж, нийтийн эзэмшлийн газрыг баталгаажуулахын тулд боломжит загвар төслүүдийг бүр эхнээс нь сонгох шаардлагатай;
- (2) Дээр дурдсан хэсэгт (1) үндэслэн сонгосон гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах загвар төслүүдийг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийг хуваарилан, хэрэгжүүлэх шаардлагатай. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн зардалд зураг төсөл, төслийн төлөвлөгөөний төсөл, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах зардал болон дэд бүтцийн ажлын зураг боловсруулах зардал ба зам, бохир ус цэвэрлэх байгууламж, ус хангамж, дулаан хангамж, гудамжны гэрэлтүүлгийг барьж байгуулах барилга угсралтын ажлын зардал мөн нөхөх олговор, инженерийн бэлтгэл ажил, газар шорооны ажлын зардал багтана;
- (3) МАЭ-ээс зохион байгуулж буй мэргэшүүлэх сургалтын хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны модулийг мэргэжилтнүүдэд ойлгуулах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талаар болон ялангуяа төслийн төлөвлөлтийн үе шатны талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэх нь төсөл хэрэгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой юм. Дээр 1-р хэсэгт дурдсан үр дүнд хүрэхийн тулд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн талаар илүү сайн ойлголттой мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх нь чухал юм;

- (4) ЖТБ-ын зүгээс хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг зохих ёсоор эрхлэн явуулах Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулсан. НЗДТГ-т уг саналыг хүлээн авч, хэрэгжүүлэхийг зөвлөж байна;
- (5) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтэд зүй зохистой хяналт, шинжилгээ хийх ба мэдээллийг иргэдэд хүргэх шаардлагатай;
- (6) ЖТБ-ийн зүгээс бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлого боловсруулан, санал болгосон. Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогод тус санал болгож буй бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг тусгахыг хичээнгүйлэн зөвлөж байна. Энэ нь хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа тэр дундаа дэд бүтцийн үйчилгээнд байшин сууцаа холбох иргэдийн хувьд чухал ач холбогдолтой юм. (2018 оны 7-р сарын 13-ны өдрийн Төслийн хяналт, шинжилгээний тайлангийн Хувилбар 7-г үзнэ үү)

4. Төслийн хяналт, шинжилгээний ex-post үнэлгээ

Монгол Улсын Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийг (2 дугаар үе шат) хэрэгжүүлж дууссаны дараа ЖАЙКА-гийн зүгээс хяналт, шалгалт хийнэ. Дор дурдсан зүйлсийг шалгана уу. Үүнд:

- (1) Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журмын төслийг эцэслэн боловсруулж, БХБ-ын Сайдын тушаалаар батлуулсан эсэх;
- (2) Дэд бүтцийн төвийг барьж байгуулах төслийн үйл явц ба Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлж буй эсэх;
- (3) Төсөв хөрөнгийг тусгасан байдал ба түүнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх төсөв хөрөнгө багтсан эсэх. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх төсөвт дэд бүтцийн ажлын зураг боловсруулах зардал, барилга угсралтын ажлын зардал, нөхөх олговор, нүүлгэн шилжүүлэлтийн зардал г.м орно;
- (4) Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль болон хуулийг хэрэгжүүлэх дүрэм журмын дагуу хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байгаа эсэх. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчидтэй хэлэлцсэний үндсэн дээр боловсруулж, загвар төслийг хэрэгжүүлэх нь чухал юм;
- (5) ЖАЙКА-гийн Төслийн багийн санал болгосон бага орлоготой өрхүүдийг орон сууцаар хангах бодлогыг төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогод

тусгасан эсэх;

- (6) Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслийн үйл явц болон хувийн компаниуд тендерт оролцохгүй байгаа тул ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулгаж, шинээр барих төслүүдийн хүрээнд түрээсийн орон сууцыг барьж байгуулж байгаа эсэх. Эдгээр зарим төслүүдийг НИТХ-ын 2014 оны 90-р тогтоолоор баталсан “Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах журам”-ын дагуу хэрэгжүүлж байгаа ба бусад төслүүд нь БХБ-ын Сайдын 2016 оны 7-р сарын 5-ны өдрийн 126-р тушаалаар баталсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ыг хүчин төгөлдөр мөрдөж эхэлсний дараа хэрэгжиж эхэлсэн;
- (7) Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл явц ба Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль болон хуулийг хэрэгжүүлэх дүрэм журмын дагуу тухайн төслийг хэрэгжүүлж байгаа эсэхийг нягтлан үзэх, шаардлагатай арга хэмжээ авах. Ихэнхи гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдийг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль батлагдахаас өмнө хэрэгжүүлж эхэлсэн тул НИТХ-ын 2013 оны 3/31-р тогтоолоор баталсан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”-ын дагуу хэрэгжүүлж байна.
- (8) Мэргэшүүлэх сургалтын хүрээнд ЖАЙКА-гийн Төслийн багийн боловсруулсан гарын авлага болон MUGCUP2 төслийн сургалтад хамрагдсан сургагч багш нарыг оролцуулан хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар сургалт явуулж буй эсэх зэрэг болно.

(2) Хамтран ажилласан байгууллагуудын мэргэжилтнүүдийн нэрсийн жагсаалт

1) Төслийн Удирдах хороо

Төслийн Удирдах хороо	Төсөл эхлэх үед (2015 оны 3-р сарын 17)	Эхний өөрчлөлт (2016 оны 3-р сарын 24)	Төсөл дуусах үед (2016 оны 9-р сарын 22)
Төслийн Удирдах хороо	<p>Дарга: БХБЯ-ны Дэд сайд Г. Байгалмаа</p> <p>Дэд дарга: Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч С. Очирбат</p> <p>Нарийн бичгийн дарга: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М. Батбаяр</p> <p>НЗДТГ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С. Баярбаатар</p>	<p>Дарга: БХБЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М. Болортуяа</p> <p>Дэд дарга: Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч С. Очирбат</p> <p>Нарийн бичгийн дарга: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Ууганбаяр</p> <p>НЗДТГ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С. Баярбаатар</p>	<p>Дарга: БХБЯ-ны Дэд сайд Ш. Лхамсүрэн</p> <p>Дэд дарга: Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П. Баярхүү</p> <p>Нарийн бичгийн дарга: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б. Гунболд</p> <p>НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г. Өлзийбаяр</p>

Төслийн Удирдах хороо	Төсөл эхлэх үед (2015 оны 3-р сарын 17)	Эхний өөрчлөлт (2016 оны 3-р сарын 24)	Төсөл дуусах үед (2016 оны 9-р сарын 22)
	<p>Гишүүд:</p> <p>Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Н. Нарангэрэл</p> <p>БХБЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга У. Отгонбаяр</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын дарга Б. Баасан</p> <p>БХБЯ-ны Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын дарга Ц. Ганбат</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хот төлөвлөлтийн албаны дарга А. Амарсайхан</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ж. Батсайхан</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Кадастрын албаны дарга Р. Ганхуяг</p> <p>Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектор Н. Нацагдорж</p>	<p>Гишүүд:</p> <p>Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Н. Нарангэрэл</p> <p>БХБЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч <u>Х. Батболд</u></p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч <u>Л. Чинзориг</u></p> <p>БХБЯ-ны Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын дарга <u>З. Энх-Оргил</u></p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга <u>А. Хурэлшагай</u></p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ж. Батсайхан</p> <p>Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р. Ганхуяг</p> <p>Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектор <u>О. Одбаяр</u></p>	<p>Гишүүд:</p> <p>Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга</p> <p>БХБЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга</p> <p>БХБЯ-ны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</p> <p>БХБЯ-ны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга</p> <p>Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р. Ганхуяг</p> <p>Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектор</p>

Төслийн Удирдах хороо	Төсөл эхлэх үед (2015 оны 3-р сарын 17)	Эхний өөрчлөлт (2016 оны 3-р сарын 24)	Төсөл дуусах үед (2016 оны 9-р сарын 22)
	<p>Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газрын дарга Ш. Ганхуяг</p> <p>Нийслэлийн өмчийн харилцааны газрын Кадастрын хэлтсийн дарга Б. Загдсамбар</p> <p>Нийслэлийн Авто замын газрын орлогч дарга Д. Баясгалан</p> <p>“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” НӨҮГ-ын дарга С. Цахиур</p> <p>“Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл” ОНӨҮГ-ын дарга А. Лхагвадорж</p> <p>Нийслэлийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирал Б. Тэлмэн</p> <p>Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мүцүми Сато</p> <p>Төслийн менежер Такео Очи</p>	<p>Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газрын дарга <u>М. Ганбаатар</u></p> <p>Нийслэлийн өмчийн харилцааны газрын Хуулийн хэлтсийн дарга <u>Э. Аримүнгэрэл</u></p> <p>Нийслэлийн Авто замын газрын орлогч дарга Д. Баясгалан</p> <p>“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” НӨҮГ-ын дарга С. Цахиур</p> <p>“Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл” ОНӨҮГ-ын дарга А. Лхагвадорж</p> <p>Нийслэлийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирал Б. Тэлмэн</p> <p>Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мүцүми Сато</p> <p>Төслийн менежер Такео Очи</p>	<p>Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга</p> <p>Нийслэлийн Газрын албаны дарга</p> <p>Нийслэлийн Авто замын газрын орлогч дарга</p> <p>“Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” НӨҮГ-ын дарга</p> <p>Нийслэлийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирал</p> <p>Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мүцүми Сато</p> <p>Төслийн менежер Такео Очи</p>

2) Ажлын хэсэг

Ажлын хэсэг	Төсөл эхлэх үед (2015 оны 3-р сарын 17)	Эхний өөрчлөлт (2016 оны 3-р сарын 24)	Төсөл дуусах үед (2017 оны 2-р сарын 17)
<p>Дэд төсөл 2 Ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М. Батбаяр</p> <p>Нарийн бичгийн дарга: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Э. Дондмаа</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Ууганбаяр</p> <p>Нарийн бичгийн дарга: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Э. Дондмаа</p>	<p>Ажлын хэсгийн ахлагч: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Гүнболд</p> <p>Нарийн бичгийн дарга: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Д. Бэлэгсайхан</p>
	<p>Гишүүд: БХБЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Үл хөдлөх хөрөнгийн зах зээл, гадаадын хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ю. Доржлагма</p> <p>БХБЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Г. Болормаа</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д. Бэлэгсайхан</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн М. Гантөмөр</p>	<p>Гишүүд: БХБЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Үл хөдлөх хөрөнгийн зах зээл, гадаадын хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ю. Доржлагма</p> <p>БХБЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Г. Болормаа</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д. Бэлэгсайхан</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн М. Гантөмөр</p>	<p>Гишүүд: БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн М. Гантөмөр</p>

Ажлын хэсэг	Төсөл эхлэх үед (2015 оны 3-р сарын 17)	Эхний өөрчлөлт (2016 оны 3-р сарын 24)	Төсөл дуусах үед (2017 оны 2-р сарын 17)
<p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн Э. Ариунням</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн П. Энхмандах</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн Б. Гоёсайхан</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Б. Оюунчимэг</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Р. Батчимэг</p> <p>БХБЯ-ны Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн З. Энх-Оргил</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга А. Хүрэлшагай</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хот төлөвлөлтийн албаны дарга А. Амарсайхан</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн</p>	<p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн Э. Ариунням</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн П. Энхмандах</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн Б. Гоёсайхан</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Б. Оюунчимэг</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Р. Батчимэг</p> <p>БХБЯ-ны Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын мэргэжилтэн Г. Цэрмаа</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга А. Амарсайхан</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн</p>	<p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн Э. Ариунням</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн П. Энхмандах</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн Б. Гоёсайхан</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Б. Оюунчимэг</p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Р. Батчимэг</p> <p>БХБЯ-ны Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын мэргэжилтэн Г. Цэрмаа</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга А. Амарсайхан</p> <p>Газрын харилцаа, геодези, зураг зүйн</p>	<p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн <u>Б. Нямдаш</u></p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн</p> <p>БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын мэргэжилтэн</p> <p>БХБЯ-ны Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн <u>Ү. Бадамсүрэн</u></p> <p>БХБЯ-ны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн <u>О. Энхтүяа</u></p> <p>БХБЯ-ны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн <u>Б. Оюунчимэг</u></p> <p>БХБЯ-ны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн <u>Р. Батчимэг</u></p> <p>БХБЯ-ны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн <u>Г. Цэрмаа</u></p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Бүс нутаг, хот төлөвлөлтийн хэлтсийн дарга <u>О. Одбаяр</u></p>

Ажлын хэсэг	Төсөл эхлэх үед (2015 оны 3-р сарын 17)	Эхний өөрчлөлт (2016 оны 3-р сарын 24)	Төсөл дуусах үед (2017 оны 2-р сарын 17)
